



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/481

Улаанбаатар хот

Нийслэлийн Ерөнхий боловсролын 17 дугаар сургуулийн эргэлтийн бус хөрөнгийг
балансаас балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын даргын 2024 оны А/481 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 16,240,000.00 (арван зургаан сая хоёр зуун дөчин мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу балансад шилжүүлж данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн Ерөнхий боловсролын 17 дугаар сургууль (П.Эрдэнэжаргал)-д зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Чингэлтэй дүүргийн 83 дугаар цэцэрлэг (Т.Сэлэнгэ)-т, Чингэлтэй дүүргийн 56 дугаар цэцэрлэг (Б.Бямбасайхан)-т, Чингэлтэй дүүргийн 224 дүгээр цэцэрлэг (П.Амарзаяа)-т, Чингэлтэй дүүргийн 31 дүгээр цэцэрлэг цэцэрлэг (В.Цэрэнпагма)-т, Чингэлтэй дүүргийн 277 дугаар цэцэрлэг (Ц.Мөнхзул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

В.Оюумаа
В.ОЮУМАА

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний
өдрийн 128 дугаар тушаалын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллага: Нийслэлийн ерөнхий боловсролын 17 дугаар сургууль

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжээ	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл /2023 оны 12 сарын 30-ны өдрийн байдлаар/	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэх байгууллага	Шилжүүлэн авах байгууллага
1	1-р хоолны тогоо 100л	2022	ш	1	3,100,000.00	3,100,000.00	516,666.66	2,583,333.34	17-р сургууль	83-р цэцэрлэг
2	Жигнүүр 12 лист	2022	ш	1	1,100,000.00	1,100,000.00	384,999.93	715,000.07	17-р сургууль	56-р цэцэрлэг
3	Будаа агшаагч 28л	2022	ш	1	440,000.00	440,000.00	153,999.93	286,000.07	17-р сургууль	57-р цэцэрлэг
4	Цахилгаан пийшин 4 ширэм 2 листтэй	2022	ш	1	3,100,000.00	3,100,000.00	1,085,000.07	2,014,999.93	17-р сургууль	224-р цэцэрлэг
5	Махны машин	2022	ш	1	1,150,000.00	1,150,000.00	402,500.07	747,499.93	17-р сургууль	31-р цэцэрлэг
6	Хөлдөөгч 750л	2022	ш	1	2,300,000.00	2,300,000.00	804,999.93	1,495,000.07	17-р сургууль	277-р цэцэрлэг
7	2-р хоолны тогоо 80л	2022	ш	1	4,600,000.00	4,600,000.00	1,610,000.07	2,989,999.93	17-р сургууль	83-р цэцэрлэг
8	Бэлтгэлийн ширээ	2022	ш	1	450,000.00	450,000.00	157,500.00	292,500.00	17-р сургууль	83-р цэцэрлэг
Дахин үнэлсэн хөрөнгийн дүн					16,240,000.00	16,240,000.00	5,115,666.66	11,124,333.34		